

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Заг сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БНА-2022/70/НА-СТА-ТШЗ**

<p>Баянхонгор 2022 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn</p>
-------------------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
төгрөгөөр	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2.1 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Төлбөрийн акт	16
4.2 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

№ 2/113

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Заг сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Заг сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a circular emblem. The signature is a stylized, cursive script.

Б.МӨНХБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	66,249,850.00	69,187,178.00
33	АВЛАГА	00.00	19,424.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	19,424.00
35	БАРАА МАТЕРИАЛ	48,945,850.00	47,152,354.00
351	Түүхий эд материал	36,634,400.00	33,807,000.00
35110	Тусгай зориулалттай материал	36,634,400.00	33,807,000.00
354	Хангамжийн материал	11,311,450.00	13,345,354.00
35410	Бичиг хэргийн материал	61,600.00	267,000.00
35420	Аж ахуйн материал	1,954,600.00	3,783,104.00
35470	Бусад хангамжийн материал	9,295,250.00	9,295,250.00
35600	Мал амьтад	1,000,000.00	00.00
36	НӨӨЦИЙН БАРАА	17,304,000.00	22,015,400.00
36300	Тэжээлийн нөөц	17,304,000.00	22,015,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,045,734,541.30	1,016,021,823.09
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,045,734,541.30	1,016,021,823.09
392	Биет хөрөнгө	1,033,684,541.30	1,001,992,656.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	532,759,951.00	532,759,951.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-44,068,033.42	-58,696,869.70
39203	Авто-тээврийн хэрэгсэл	113,884,800.00	91,384,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-44,525,442.36	-50,254,567.36
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	312,368,612.00	314,750,112.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-271,164,225.86	-287,866,757.68
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,993,585.00	23,993,585.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18,354,672.16	-20,339,120.18
39214	Бусад үндсэн хөрөнгө	514,529,604.00	579,029,604.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-284,080,036.90	-321,408,480.66
39216	Дуусаагүй барилга, байгууламж	198,105,400.00	198,105,400.00
39217	Ном	235,000.00	535,000.00
393	Биет бус хөрөнгө	12,050,000.00	14,029,166.67
39301	Програм хангамж	200,000.00	2,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-200,000.00	-220,833.33
39303	Бусад биет бус хөрөнгө	12,050,000.00	12,050,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,111,984,391.30	1,085,209,001.09
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,111,984,391.30	1,085,209,001.09
51	Засгийн газрын хувь оролцоо	1,111,984,391.30	1,085,209,001.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	539,845,992.00	539,845,992.00
51101	Өмч: - төрийн	539,845,992.00	539,845,992.00
512	Хуримтлагдсан үр дүн	252,744,026.10	225,968,635.89
1210	Өмнөх үеийн үр дүн	252,744,026.10	252,744,026.10
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-26,775,390.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	319,394,373.20	319,394,373.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,111,984,391.30	1,085,209,001.09

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	518,763,097.00	472,267,769.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	155,586,420.00	77,997,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	155,586,420.00	77,997,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	155,586,420.00	1,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	1,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	155,286,420.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө	0.00	66881500.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал	0.00	10115500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	363,176,677.00	394,270,769.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,168,577.00	32,581,369.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	30,289,369.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,718,577.00	2,292,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,450,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	339,008,100.00	361,689,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	339,008,100.00	361,689,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	452,034,192.20	499,043,159.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	452,034,192.20	499,043,159.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	436,798,372.89	468,861,895.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,905,415.00	208,848,721.00
210101	Үндсэн цалин	209,905,415.00	208,848,721.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,402,856.69	24,968,583.75
210201	Тэтгэврийн даатгал	17,284,886.69	17,257,594.83
210202	Тэтгэмжийн даатгал	2,254,741.00	1,939,067.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,751,410.00	1,555,685.61
210204	Ажилгүйдлийн даатгал	448,400.00	396,521.37
210205	Эрүүл мэндийн даатгал	4,663,419.00	3,819,713.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,213,495.00	28,493,066.00
210301	Гэрэл, цахилгаан	3,700,558.00	3,663,862.00
210302	Түлш, халаалт	18,280,430.00	24,829,204.00
210303	Цэвэр, бохир ус	232,507.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,914,817.00	27,991,586.00
210401	Бичиг хэрэг	3,923,700.00	3,768,090.00
210402	Тээвэр, шатахуун	21,160,200.00	17,247,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	591,272.00	1,073,700.00
210404	Ном, хэвлэл	52,200.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	270,000.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,000.00	966,496.00
210408	Бараа материал акталсны зардал	15,877,445.00	4,576,000.00
2105	Нормативт зардал	00.00	200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	3,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,518,400.00	4,602,500.00
210702	Дотоод албан томилолт	5,083,000.00	4,602,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,435,400.00	00.00

**Заг сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,218,219.00	45,491,881.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,310,219.00	41,403,981.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	498,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,000.00	16,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	8,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	95,625,170.20	125,265,557.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,235,650.00	25,453,839.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	917,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	77,189,520.20	98,894,218.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,235,819.31	30,181,264.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,400,000.00	5,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,400,000.00	5,200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,835,819.31	24,981,264.25
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,575,818.31	23,522,420.25
213404	Хөрөнгийн	1,260,001.00	1,458,844.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	66,728,904.80	-26,775,390.21
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	66,728,904.80	-26,775,390.21

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	363,476,677.00	395,270,769.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	300,000.00	1,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	300,000.00	1,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	300,000.00	1,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	363,176,677.00	394,270,769.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,168,577.00	32,581,369.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	30,289,369.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,718,577.00	2,292,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,450,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	339,008,100.00	361,689,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	339,008,100.00	361,689,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	362,516,677.00	392,970,769.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	362,516,677.00	392,970,769.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	347,280,857.69	362,789,505.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,905,415.00	208,848,721.00
210101	Үндсэн цалин	209,905,415.00	208,848,721.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,402,856.69	24,988,007.75
210201	Тэтгэврийн даатгал	17,268,437.69	17,277,018.83
210202	Тэтгэмжийн даатгал	2,254,741.00	1,939,067.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,751,410.00	1,555,685.61
210204	Ажилгүйдлийн даатгал	448,400.00	396,521.37

**Заг сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210205	Эрүүл мэндийн даатгал	4,679,868.00	3,819,713.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,213,495.00	28,493,066.00
210301	Гэрэл, цахилгаан	3,700,558.00	3,663,862.00
210302	Тулш, халаалт	18,280,430.00	24,829,204.00
210303	Цэвэр, бохир ус	232,507.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,195,672.00	22,884,990.00
210401	Бичиг хэрэг	3,568,300.00	3,973,490.00
210402	Тээвэр, шатахуун	19,798,300.00	15,887,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	993,272.00	1,073,700.00
210404	Ном, хэвлэл	52,200.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	270,000.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,513,600.00	1,590,500.00
2105	Нормативт зардал	00.00	200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	3,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,518,400.00	4,602,500.00
210702	Дотоод албан томилолт	5,083,000.00	4,602,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,435,400.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,635,119.00	43,250,881.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,727,119.00	39,162,981.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	498,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,000.00	16,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	8,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,409,900.00	26,521,339.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,209,900.00	25,521,339.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,235,819.31	30,181,264.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,400,000.00	5,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,400,000.00	5,200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,835,819.31	24,981,264.25
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,575,818.31	23,522,420.25
213404	Хөрөнгийн	1,260,001.00	1,458,844.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	960,000.00	2,300,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	960,000.00	2,300,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	960,000.00	2,300,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	960,000.00	2,300,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	960,000.00	2,300,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-960,000.00	-2,300,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	төгрөгөөр
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	539,845,992.00	319,394,373.20	186,015,121.30	1,045,255,486.50
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	539,845,992.00	319,394,373.20	186,015,121.30	1,045,255,486.50
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	66,728,904.80	66,728,904.80
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	539,845,992.00	319,394,373.20	252,744,026.10	1,111,984,391.30
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	539,845,992.00	319,394,373.20	252,744,026.10	1,111,984,391.30
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	539,845,992.00	319,394,373.20	252,744,026.10	1,111,984,391.30
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-26,775,390.21	-26,775,390.21
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	539,845,992.00	319,394,373.20	225,968,635.89	1,085,209,001.09

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	362,689,400.00	339,166,979.75	23,522,420.3	93.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	362,689,400.00	339,166,979.75	23,522,420.3	93.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	357,489,400.00	333,966,979.75	23,522,420.3	93.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,680,100.00	208,848,721.00	831,379.0	99.6
210101	Үндсэн цалин	209,680,100.00	208,848,721.00	831,379.0	99.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,509,300.00	24,988,007.75	3,521,292.3	87.6
210201	Тэтгэврийн даатгал	20,062,300.00	17,277,018.83	2,785,281.2	86.1
210202	Тэтгэмжийн даатгал	2,111,800.00	1,939,067.98	172,732.0	91.8

**Заг сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210203	ҮОМШӨ-ний даатгал	1,689,500.00	1,555,685.61	133,814.4	92.1
210204	Ажилгүйдлийн даатгал	422,100.00	396,521.37	25,578.6	93.9
210205	Эрүүл мэндийн даатгал	4,223,600.00	3,819,713.96	403,886.0	90.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,851,800.00	28,493,066.00	1,358,734.0	95.4
210301	Гэрэл, цахилгаан	4,310,900.00	3,663,862.00	647,038.0	85.0
210302	Түлш, халаалт	25,540,900.00	24,829,204.00	711,696.0	97.2
2104	Хангамж, бараа материалын зардал	28,198,800.00	23,184,990.00	5,013,810.0	82.2
210401	Бичиг хэрэг	3,973,500.00	3,973,490.00	10.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	15,887,300.00	15,887,300.00	0.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,078,000.00	1,073,700.00	4,300.0	99.6
210404	Ном, хэвлэл	300,000.00	300,000.00	0.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,360,000.00	360,000.00	5,000,000.0	6.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,600,000.00	1,590,500.00	9,500.0	99.4
2105	Нормативт зардал	200,000.00	200,000.00	0.0	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	200,000.00	0.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00	0.0	100.0
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00	0.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	6,145,500.00	4,602,500.00	1,543,000.0	74.9
210702	Дотоод албан томилолт	6,145,500.00	4,602,500.00	1,543,000.0	74.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,403,900.00	12,128,356.00	1,275,544.0	90.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,281,900.00	8,040,456.00	1,241,444.0	86.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	498,500.00	1,500.0	99.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	18,000.00	16,900.00	1,100.0	93.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	8,500.00	31,500.0	21.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00	0.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38500000.00	28521339.00	9,978,661.0	74.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,500,000.00	27,521,339.00	9,978,661.0	73.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00	0.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5200000.00	5200000.00	0.0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,200,000.00	5,200,000.00	0.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,200,000.00	5,200,000.00	0.0	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	362,689,400.00	339,166,979.75	23,522,420.3	93.5

**Заг сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	361,689,400.00	338,166,979.75	23,522,420.3	93.5
132001	Орон нутгийн төсвөөс	361,689,400.00	338,166,979.75	23,522,420.3	93.5
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	1,000,000.00	0.0	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,000,000.00	0.0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19	19	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	3	3	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	15	15	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	1	1	0.0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	19	19	0.0	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8	0.0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	0.0	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6	0.0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22908576.00	31,122,525.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22908576.00	31,122,525.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22908576.00	31,122,525.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22908576.00	31,122,525.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22908576.00	31,122,525.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12600001.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12600001.00	00.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	12600001.00	00.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	24,168,577.00	31,122,525.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,168,577.00	31,122,525.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,718,577.00	30,191,525.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,450,000.00	931,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Заг сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бунчинсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Заг сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022-ны 2 дүгээр сарын 23 өдрийн 08 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Заг сумын ЗДТГ-ын Д.Гантуул, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ж.Отгонбаатар нар зурж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулжээ.

3.2.1 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Заг сумын ЗДТГ нь “Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх” эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүү хяналт, аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Заг сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Заг сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 452,034.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,780.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,746.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 5,239.9 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Заг сумын ЗДТГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,085,209.0 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 26,775.4 мянган төгрөгөөр буюу 2.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	66,249.9	69,187.2	2,937.3
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	19.4	19.4
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	66,249.9	69,167.8	2,917.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,045,734.5	1,016,021.8	(29,712.7)
Үндсэн хөрөнгө	1,708,127.0	1,754,808.5	46,681.5
Хуримтлагдсан элэгдэл	(662,392.4)	(738,786.6)	(76,394.2)
Нийт хөрөнгө	1,111,984.4	1,085,209.0	(26,775.4)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,111,984.4	1,085,209.0	(26,775.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,111,984.4	1,085,209.0	(26,775.4)

/Эх сурвалж: Заг сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлангаас/

Авлагын дансны 19.4 мянган төгрөг болж 19.4 мянган төгрөгөөр өссөн нь ажиллагсадтай холбоотой авлага өссөнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 69,167.8 мянган төгрөг болж 2,917.9 мянган төгрөгөөр өссөн нь өвс тэжээлийн үлдэгдэл 4,711.4 мянга, бичиг хэргийн зардал 205.4 мянга, аж ахуйн материал 1,828.5 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна. Мөн сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 5,000.0 мянган төгрөгийн өвс тэжээл, ковид 19 цар тахалтай холбоотой АА нэгж ард иргэдээс 1,360.0 мянган төгрөгийн шатахуун, 3,250.0

мянган төгрөгийн нэг удаагийн хамгаалах хэрэгсэл болон аж материал, аймгийн ЗДТГ-аас 254.5 мянган төгрөгийн аж ахуйн материал, Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлаас цаашид ашиглагдах 251.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэн авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,754,808.5 мянган төгрөг болж 46,681.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 2,300.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 66,881.5 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгө шилжүүлэн авч аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 52 дугаар тогтоолоор 22,500.0 мянган төгрөгийн өртөгтэй тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар худалдсан байна. Мөн тайлант хугацаанд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бусад хөрөнгөнд 64,500.0 мянган төгрөгийн байгууламж, аймгийн ХХААГ-аас 2,381.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,085,209.0 мянган төгрөг болж 26,775.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 26,775.4 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 311,065.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 311,065.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 26,427.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 337,492.3 мянган төгрөгөөр анх батлагдсан ба төсвийн тодотголоор 25,197.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, бараа үйлчилгээний зардлыг нэмэгдүүлэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 362,689.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 361,689.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 361,689.4 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 1,000.0 мянган төгрөгийн орлого орж, урсгал үйл ажиллагаанд 339,167.0 мянган төгрөгийг зарцуулж орон нутгийн төсвийн санхүүжилтээс 23,522.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 93.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлаас 831.4 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 3,521.3 мянга, хангамж бараа материалын зардал 5,013.8 мянга, дотоод албан томилот 1,543.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,275.5 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 9,978.7 мянган төгрөг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 32,581.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 31,122.5 мянган төгрөг зарцуулж 1,458.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Үүнд дээд шатны төсөв захирагчаас Чандмань-Баянхонгор ХК-аас 2,292.0 мянган төгрөгийн усны төлбөр, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгийн дансанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 3,122.7 мянга, аймгийн ХХААГ-аас оготно устгалын 9,072.0 мянга, аймгийн Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 813.7 мянга, аймгийн ГБХЗХГ-аас хамтарсан багийн санхүүжилт 300.0 мянга, цахим тендерийн хураамж 490.0 мянга, буудлын мөнгө 20.0 мянга нийт 32,581.4 мянган төгрөгийн орлого төвлөрч 31,122.5 мянган төгрөгийг зарцуулж усны төлбөрийн үлдэгдэл 1,458.8 мянган төгрөгийг сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитор Б.Азбаяр аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 74 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 86 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 499,043.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 47,008.9 мянган төгрөгөөр буюу 10.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь, байр ашиглалттай холбоотой зардал, нормативд зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардал нэмэгдэж цалин, хөлс нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл хангамж, бараа материалын зардал, томиллолт, зочны зардал өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 385,381.3 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1 гүйлгээний 8,000.0 мянган төгрөгийг мэдээлээгүй байна. Мөн төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 9 сар, 3 дугаар улирал, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 9 сар, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө бүтэн жилээр Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр) 1 сар, 3 сар, 5 сар, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) 9 сар, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт (Сар бүр) 9 сарын мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	3	1	
3	Улирал бүр	1	4	3	1	
4	Сар бүр	3	36	34	2	
5	Тухай бүр	8	96	91	5	
	Нийт	27	151	140	9	2

Эх сурвалж: Заг сумын ЗДТГ-ын 2021 оны шилэн дансны мэдээлэл

3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Тайлант онд нийт 362,689.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 339,167.0 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 23,522.4 мянган төгрөг буюу төсвийн 6.5 хувийг буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 34,754.5 мянган төгрөгөөр, тодотголоор 4,902.7 мянган төгрөгөөр бууруулж оны эцэст 28,493.1 мянган төгрөгийг зарцуулсан нь дээрх тогтоолын 1.8 дах заалттай нийцэж байна.

3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд дотуур байрны хоол хүнс,

үдийн цайны хүнсний материал нийлүүлэх худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан ба 446.6 мянган төгрөгийн 4 төрлийн зөрчил илэрснээс 199.6 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 245.0 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага өгч, автомашины эзэмшигчтэй холбоотой 1 зөвлөмж өгсөн ба тус автомашинуудын эзэмшигчийн гэрчилгээ гараагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 12,520.8 мянган төгрөгийн 4 зөрчил илэрч 1,859.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчил давтан гаргахгүй 10,660.9 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүлээ.

4.1 Төлбөрийн акт

1. Засгийн газрын 2020.12.13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор “Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” баталсан ба Баянхонгор Чандмань-Баянхонгор ХК-аас усны төлбөрт нэмэлт санхүүжилтийн дансанд 2,292.0 мянга, үндсэн дансанд 150.0 мянган төгрөг орлого орсон бөгөөд үүнээс байгууллагын бичиг хэргийн зардалд 931.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 211 дүгээр тогтоолын 5-т “Төрийн байгууллагын цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус, хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг төлөвлөсөн хэмжээнээс бууруулахгүй, өөр зардалд шилжүүлэхгүйгээр цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур, ус хангамж, ариутгах татуурга, хог хаягдлын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагад шууд шилжүүлж байхыг төсвийн бүх шатны захирагч нарт даалгасугай.” гэсэн заалтууд Санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Зориулалт бусаар зарцуулсан 931.0 мянган төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 9289.0 мянган төгрөгийг бэлэн авч зарцуулсан ба анхан шатны баримтын бүрдэл дутуу худалдан авсан бараа материалын е баримт хавсаргаагүй, шимтгэл тооцоог суутган тооцоогүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Суутган тооцоогүй 928.9 мянган төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнаар төлүүлж сумын орон нутгийн орлогод төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн цэстээс түүвэр хийж үзэхэд 206,187.8 мянган төгрөгийг зардал гарсан байхад санхүүгийн үр дүнгийн тайлангаар 208,848.7 мянган төгрөгөөр тайлагнаж 2660.9 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1." Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" , Сангийн сайдын 2021.10.29-ны өдрийн 190 дугаар тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын Цалин хөлс болон нэмэгдэл урамшилд "Ажиллагчдын цалин, хөлс болон хуулиар нийгмийн даатгалын шимтгэл бодогдох нэмэгдэл урамшлын зардлууд энэ ангилалд хамрагдана" гэсэн заалтууд санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт", "Нийцсэн ба зохистой байх" батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалин, НДШ-ийн нягтлан бодох бүртгэлд бүртгэхдээ Сангийн сайдын 388 тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын ажиллагсадтай холбогдсон зардлын бүртгэл, нийгмийн даатгалын шимтгэлийн бүртгэлийг дагаж мөрдөх.

1. Тус байгууллага нь 2021 онд нийт 385,381.3 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1 гүйлгээний 8,000.0 мянган төгрөгийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мэдээллийг хугацаанд нь үнэн зөв мэдээлж байх.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Заг сумын ЗДТГ	4	12,520.8			2	1,859.9			2	10,660.9

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

_____оОо_____